

”ГЭМТЭГСДИЙГ АВРАХ ЛАВШРУУЛСАН ТУСЛАМЖ” СЭДЭВТ СУРГАЛТЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВТӨЙ ХАМТРАН УЛСЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, БОЭТ БОЛОН АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЭМЧ НАРТ ЯВУУЛСАН СУРГАЛТЫН ТАЙЛАН



2015 оны 11 дүгээр сарын 5-наас 10-ны өдрүүдэд 2 дахь удаагийн ГАЛТ сургалтыг зохион байгууллаа. Олон улсын мэргэшсэн 6 сургагч багш (АНУ, Австрали,



Малайз, Тайланд), нэг сувилагч (Австрали), 2 сургагч багш Монголоос тус тус оролцлоо. Сургалтанд Улаанбаатар хотоос УНТЭ, АШУУИС, ГССҮТ, УГТЭ, орон нутгаас хүн ам, зам тээврийн хөдөлгөөн ихтэй Төв, Баянхонгор, Өвөрхангай, Ховд, Өмнөговь аймгуудын бүсийн оношлогоо эмчилгээний төвүүд болон




нэгдсэн эмнэлгийн мэс засал, гэмтлийн 16 эмчийг нарыг оролцуулан сургалтыг зохион байгууллаа.



”ГЭМТЭГСДИЙГ АВРАХ ЛАВШРУУЛСАН ТУСЛАМЖ” СЭДЭВТ СУРГАЛТ явагдаж байх үед БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Л.Гантөмөр болон УЛСЫН ИХ ХУРЛЫН гишүүд С.Одонтуяа,

С.Ламбаа нар ирж танилцан, дэмжиж ажиллахаа мэдэгдлээ.



Энэхүү сургалтын өгөөж нь Монголын орон нутгийн эмч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэхээс гадна гэмтсэн өвчтөнд цаг алдахгүйгээр, олон улсын стандартын дагуу тусламж үйлчилгээг амь



насыг аврахад үзүүлэхэд оршино.

Сургалтанд: ГССҮТ, УНТЭ, ШУГТЭ, АШУУИС, Өвөрхангайн БОЭТөв, Өмнөговь БОЭТөв, Төв аймгийн нэгдсэн эмнэлэг, Өмнөговь БОЭТөв, Ховд БОЭТөв, Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг нийт 16



мэргэжилтэн сургалтанд хамрагдаад байна. Дээрх эмч нарт **”ГЭМТЭГСДИЙГ АВРАХ ЛАВШРУУЛСАН ТУСЛАМЖ”** сургалтыг 7 багш удирдан явуулсан. Үүнд: Рей Прайс Америкаас, Майк Холланд, Леслей нар Австралиас, Андре Дас Малайзаас, Вурапат, Нарайан нар Тайландаас, Л.Ганболд, С.Бурмаа

Монголоос тус тус ирж сургагч багшаар ирж хичээл заалаа.



”ГЭМТЭГСДИЙГ АВРАХ ЛАВШРУУЛСАН ТУСЛАМЖ” сургалтын оролцогч нарт лекц хийгдэж байна. Лекцийг Англи, Монгол хэлээр 2 дэлгэцэн дээр зэрэг үзүүлэн багш, сургагч нарын яриаг Англиас Монгол хэлрүү шууд орчуулан явуулсан.



Гэмтэгсдийг аврах лавшруулсан тусламжийн сургалтан хэрэглэгддэг Trauma map дээр ажиллаж байна. Энэхүү муляж дээр ажиллахад нэг хүн дунджаар 60\$ үнэтэй материал ашигладаг. Хүн бүр үйлдлийг гардаж хийдэг бөгөөд өөрт буй нөөцийн хүрээнд хэрхэн анхны тусламж үзүүлэх талаар хэлэлцдэг . ГАЛТ сургалтын онцлог нь: өртөөгөөр ажиллах явцад

сургагч багш нөр зөв арга техникийг хийж үзүүлэн дадлагашуулдаг юм.





Траума ман –д хэрэглэгдэх нэг удаагийн материалыг Гонг-Конг-оос захиж авчируулсан.

Сургалтанд оролцогчид хамгийн сүүлийн өдөр шалгалт өгч тэнцсэн тохиолдолд уг сургалтын батламжийг гардан авдаг бөгөөд гадаад оронд (Америка,



Австрали, Гонг-Конг, Тайланд, Малайз) мэс засал, мэдээгүйжүүлэгч болон гэмтлийн эмч нар 3 жилийн давтамжтайгаар дахин энэхүү сургалтанд суудаг байна. Энэхүү сургалтын үндсэн үнэ нь улс оронуудад харилцан адилгүй байдаг бөгөөд хамгийн хямд Гонг-Конгд 2000\$ үнэтэйгээр явагддаг байна.



Уг сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс **6.456.000₮** -ийн санхүүжүүлэн явуулсан.

Энэхүү сургалтыг явуулахад бүх талын дэмжлэг үзүүлсэн Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн Захирал Ч.Бат-Эрдэнэ ирж сургалтын явц болон оролцогчидтой уулзан сургалтын талаар санал бодол асуулаа.



Энэхүү сургалтыг явуулахад санхүүгийн туслалцаа үзүүлсэн Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн захирал Ч.Бат-Эрдэнэ Танд нийт сургагч багш, оролцогчид болон зохион байгуулагч нарас талархлаа илэрхийлье.

